



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/346

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Засаг даргын Жуух, Хүндэт өргөмжлөл болон бусад шагнал захиалан хийлгэсэн зардалд 830 000 төгрөг, Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажлын хэсэг манай аймагт ажилласан зардалд 1 260 600 төгрөг, Архив, Улсын бүртгэлийн газрын барилгын зураг төсөв гаргахаар манай аймагт ажилласан зардалд 383 000 төгрөг, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл” багийн зардалд 950 000 төгрөг, Ж.Хайдавын нэрэмжит гудамж, цогцолборын нээлтийн үйл ажиллагааны зардалд 323 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 3 746 700 төгрөг /Гурван сая долоон зуун дөчин зургаан мянга долоон зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/346-Bo